

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/011/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	
	Аудитын менежер:	Х.Түвшинбаяр
	Утас:315558	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Б.Цолмон
	Утас:325093	Цахим хаяг: tsolmonb@audit.gov.mn
	Аудитор:	Ж.Мөнхтуяа
	Утас: 325093	Цахим хаяг: Munkhtuyaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 176
танай _____-ны № _____-Т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА-П.АМАРТҮВШИН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 43.2 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 2,542.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд 514.0 сая төгрөг буюу 20.2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагын 1.5 хувь нь нас барсан иргэдийн, 75.7 хувь нь шүүх ажиллагаанд, 3.1 хувь нь эвлэрлийн хугацаанд, 19.7 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж авлага барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2025 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй 1,200.0 сая

C:\Users\narangui\Desktop\Баяр хэргэ 2026\2026-02-25\Хан-Уул дүүргийн 2025 Оны Санхүүгийн Тайлант.docx
1476950183

төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 137 иргэнтэй, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх 86.4 сая төгрөгийн сургалтын зардлыг 33 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зарцуулсан байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь, болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	2,295,073,828.04	2,547,471,550.00
33	АВЛАГА	2,295,073,828.04	2,547,471,550.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	2,260,863,828.04	2,542,971,550.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	1,207,220,405.04	1,552,444,717.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	359,451,889.00	331,048,549.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	594,827,730.00	573,048,549.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2,160,000.00	
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	97,203,804.00	85,589,804.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,500,000.00	4,500,000.00
33500	Бусад авлага	29,710,000.00	
33510	Байгууллагаас авах авлага	29,710,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,295,073,828.04	2,547,471,550.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	317,914,282.00
41	БОГИНО ХУГАЦААТ АР ТӨЛБӨР		317,914,282.00
41300	Өглөг		317,914,282.00
41360	Бусад өглөг		317,914,282.00
41361	Байгууллагад өгөх өглөг		317,914,282.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,295,073,828.04	2,229,557,268.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,295,073,828.04	2,229,557,268.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,295,073,828.04	2,229,557,268.00
51210	Өмнөх үеийн үр дүн	2,637,627,908.33	2,265,363,828.00
51220	Тайлант үеийн үр дүн	(342,554,080.29)	(35,806,560.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,295,073,828.04	2,547,471,550.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,257,875,300.00	2,467,850,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,257,875,300.00	2,467,850,500.00

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	3,257,875,300.00	2,467,850,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,604,300,300.00	1,498,623,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,311,784,300.00	30,620,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,292,516,000.00	1,468,003,700.00
12000	Бусад орлого	653,575,000.00	969,226,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,600,429,380.29	2,503,657,060.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,600,429,380.29	2,503,657,060.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,579,500.00	41,786,322.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,579,500.00	41,786,322.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,579,500.00	41,786,322.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,538,849,880.29	2,461,870,738.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,538,849,880.29	2,461,870,738.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,696,420,080.29	1,803,362,990.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,696,420,080.29	1,803,362,990.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	661,071,500.00	658,507,748.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	661,071,500.00	658,507,748.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(342,554,080.29)	(35,806,560.00)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(342,554,080.29)	(35,806,560.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/Төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,662,139,380.29	3,385,742,778.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,927,038,154.33	2,467,850,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,927,038,154.33	2,467,850,500.00
120004	Төсвийн байгууллагын өөрийн орлого	3,927,038,154.33	2,467,850,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,311,784,300.00	16,334,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,292,516,000.00	1,468,003,700.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,322,737,854.33	983,512,800.00
1310	Улсын төсвөөс	735,101,225.96	1,488,210,400.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	735,101,225.96	1,488,210,400.00
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО	735,101,225.96	917,892,278.00

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

145	Бусад орлого (олз)	735,101,225.96	917,892,278.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	4,662,139,380.29	3,385,742,778.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,662,139,380.29	3,385,742,778.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,579,500.00	41,786,322.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,579,500.00	41,786,322.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,579,500.00	41,786,322.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600,559,880.29	3,343,956,456.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,600,559,880.29	3,343,956,456.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,878,138,380.29	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	181,358,300.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	181,358,300.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,696,420,080.29	1,803,362,990.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,696,420,080.29	1,803,362,990.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,722,781,500.00	1,540,593,466.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,722,781,500.00	1,540,593,466.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,637,627,908.33	2,637,627,908.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(342,374,080.29)	(342,374,080.29)
3	Тайлант үеийн үр дүн		
4	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,295,253,828.04	2,295,253,828.04
5	2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,295,253,828.04	2,295,253,828.04
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(29,710,000.00)	(29,710,000.00)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,265,363,828.00	2,265,363,828.00
8	Тайлант үеийн үр дүн	(35,806,560.00)	(35,806,560.00)
9	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,229,557,268.00	2,229,557,268.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/Төгрөгөөр/

Хөтөлбөр, төслийн ангилал		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ЗӨРҮҮ	хувь
Эдийн застийн ангилал	Нийт зарлага ба Цэвэр зээлийн дүн	2,621,426,440.00	1,582,379,788.00	1,039,046,652.00	66.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,180,000.00	41,786,322.00	11,399,678.00	79.0
210	БАРАА ,АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ХУРААМЖ	53,180,000.00	41,786,322.00	11,399,678.00	79.0
210801	БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ХУРААМЖ	53,180,000.00	41,786,322.00	11,399,678.00	79.0
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,568,246,440.00	1,540,593,466.00	1,027,652,974.00	60.0
	Бусад урсгал шилжүүлэг	2,568,246,440.00	1,540,593,466.00	1,027,652,974.00	60.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	2,568,246,440.00	1,540,593,466.00	1,027,652,974.00	60.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,621,426,440.00	1,582,379,788.00	1,039,046,652.00	66.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	726,000,000.00	932,379,788.00	(206,379,788.00)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,940,322.00	(4,940,322.00)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	726,000,000.00	803,605,200.00	77,605,200.00	
350003	Урьд оны үлдэгдэл санхүүжих	-	123,834,266.00	(123,834,266.00)	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	1,895,426,440.0	650,000,000.00	1,245,426,440.00	
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	1,895,426,440.0	650,000,000.00	1,245,426,440.00	

ТБОНӨХБАУХАТХ, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 190,844.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 3 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	77,461.7	3	77,461.7	100.0
Зөвлөмж	2	113,383.0	2	113,383.0	100.0
Нийт дүн	5	190,844.7	5	190,844.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн ХУД-ийн ХЭДС-ийн дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал байна. Үүнд: Хуулийн байгууллагад хандсан хугацаа хэтэрсэн авлага барагдсан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,227.0 мянган төгрөгийн зөрчил¹ -д 3 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн 43,227.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Өмнөх онд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 20,841.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн төлөлт дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ 2 дугаар зүйлийн 2.10-т "Энэхүү гэрээг дүгнэж арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хангасан эсэхэд хяналт тавина.", 2.11-т "Санхүүгийн дэмжлэгийн явцын хяналт, гүйцэтгэлийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлүүлэх.

Илрүүлэлт-2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс 22,386.0 мянган төгрөг гэрээний хавсралт хуваарийн дагуу төлөгдөөгүй байгаа нь авлага нэмэгдэх үр дагаварт хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ 2 дугаар зүйлийн 2.10-т "Энэхүү гэрээг дүгнэж арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хангасан эсэхэд хяналт тавина.", 2.11-т "Санхүүгийн дэмжлэгийн явцын хяналт, гүйцэтгэлийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлнэ.", 4 дүгээр зүйлийн 4.3-д "Б тал гэрээний дагуу олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан, бусдад дамжуулсан, ашиглуулсан, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд А талд учруулсан хохирол (шүүхийн зардал Үндэсний аудитын байгууллагын акт, улсын байцаагчийн албан шаардлага, актаар тогтоогдсоныг)-ыг бүрэн хариуцна." гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дэмжлэгийн гэрээний хавсралт хуваарийн дагуу зээлийг хугацаанд нь эргэн төлүүлэх, хяналтыг сайжруулах, авлагыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Илрүүлэлт-3: Нас барсан иргэдийн авлагад эрсдэлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нас барсан иргэдийн авлагад эрсдэлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна	1						1					
Өмнөх онд олгосон санхүүгийн дэмжлэгээс 20,841.0 мянган төгрөгийн эргэн төлөлт дутуу байна.	1						1	20,841.0				
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс 22,386.0 мянган төгрөг гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу төлөгдөөгүй байна.	1						1	22,386.0				
Дүн	3	43,227.0					3	43,227.0				